

**“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ГАЛ УНТРААХ ТУСГАЙ
ЗОРИУЛАЛТЫН МАШИН НИЙЛҮҮЛЭХ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцлээ.

Санхүүгийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороонд ирүүлсэн болно.

Байнгын хороодын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат уг төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Бүгд Найрамдах Франц Улсаас авсан нисдэг тэргээр сургалт хийх үед гарсан ослын талаар, мөн уг нисдэг тэргэнд засвар үйлчилгээ хийсэн эсэх, Оросын Холбооны Улсаас урьд нь авч байсан МИГ онгоц, техник, тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа, баталгаат чанарын түвшин ямар байгаа талаар, нисдэг тэргийг Улаанбаатар хотод гал унтраах, гамшиг осол, аврах ажиллагаанд ашиглах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар онцгой байдлын баг бүрэлдэхүүнд шаардлагатай нисгэгч бэлдэхээс гадна эмнэлэг, үйлчилгээндээ ойрхон буух, хөөрөх нислэгийн талбай, зурвас, дэд бүтцийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх, эдийн засгийн үр ашгийг нь тооцох, цаашид хувийн хэвшлийн жижиг оврын онгоцыг ослын үед ашиглах, яаралтай үед нийслэл хотын төвд жижиг оврын онгоц буух зурвас, үйлчилгээ хийх талбайтай болох талаар ямар ажил хийж, төлөвлөж байгааг ажлын хэсгийн гишүүдээс тодруулж асуусан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан энэхүү төслийн хүрээнд бэлтгэж байгаа чадварлаг сайн нисгэгчдийг цаашид тогтвор, суурьшилтай албандаа ажиллах боломжоор хангахад анхаарах, түүнд чиглэсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, цаашид тэднийг сургагч багшаар ажиллуулж, үндэсний боловсон хүчин бэлтгэхэд анхаарах шаардлагатай талаар Онцгой байдлын байгууллагын удирдлагад анхааруулсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах автомашин, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, шатахуун түгээх станцууд, томоохон худалдааны төвүүдэд гарсан гал түймрийг унтраах, аюулт үзэгдэл, ослын голомтод түргэн шуурхай очих, цаг алдалгүй аврах ажиллагааг зохион байгуулах, гал түймэр унтраахад ашиглах учраас энэ хэлэлцээрийн төсөлд Улсын Их Хурлын гишүүд ач холбогдол өгч байгааг онцлон тэмдэглэсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх "Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.ЭНХ-АМГАЛАН

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Г.ТЭМҮҮЛЭН